



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Ерөнхий прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,968,055.80 (таван сая есөн зуун жаран найман мянга тавин таван төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Увс аймгийн Прокурорын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Хишигжаргал, Увс аймгийн Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Т.Нямжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

13 2005052
12-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 05 дугаар сарын 11 өдрийн
 129 дугаар тогтоолын хавсралт

Улсын ерөнхий Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй
 ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх
 автомашины жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	"Киа Оптима" маркийн суудлын автомашин, улсын дугаар 08-33 УБҮ, арлын дугаар KNAGN411BB5109338	2011/018	1	5,968,055.80	5,000,000.00	2	Увс аймгийн Прокурорын газар
2	Нийт дүн		1	5,968,055.80 (таван сая есөн зуун жаран найман мянга тавин таван төгрөг наян мөнгө)	5,000,000.00 (таван сая)		